**Батлав. МВХ-ны ЕРӨНХИЙЛӨГЧ Т.БАЯРХҮҮ**

## "ВОЛЕЙБОЛЫН СПОРТЫН МАСТЕР, ДАСГАЛЖУУЛАГЧ А.ЁНДОНШАРАВЫН НЭРЭМЖИТ" ӨСВӨРИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

### 1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Монголын волейболын холбоо
Завхан аймгийн ЗДТГ, БТСГ, Завхан аймгийн волейболын холбоо

Хаяг: Монголын волейболын холбоо
МҮОХ-ны байр, 402 тоот
Чингисийн өргөн чөлөө,
Улаанбаатар 14210
Утас / Факс: 976 –11 - 344340 99090301
Цахим шуудангийн хаяг: info@mva.mn

Завхан аймаг
Утас: 98750056 БТСГ 94990304 БТСГ

### 2. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

Баг тамирчид, албаны хүмүүс хүрэлцэн ирэх өдөр: 2020/10/20
Тэмцээний өдрүүд: 2020-10.21-27 нд
Баг, тамирчид, албаны хүмүүс буцах: 2020/10/28

### 3. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ХОТ & ТЭМЦЭЭН БОЛОХ ГАЗАР

Завхан аймаг, Биеийн тамир Спортын Газар

### 4. ОРОЛЦОГЧ БАГУУД

4.1 Монголын волейболын холбооны дүрмийн дагуу зохион байгуулж,өсвөрийн насны аймаг,хот, дүүрэг, сум, баг, сургууль, клубийн багууд бие даан нээлттэй оролцож болно. Урьдчилсан тоглолтонд багуудыг хэсгүүдэд хувааж тойргийн системээр явуулна.

4.2 Багийн тоглогч нь 2004 оны 1-р сарын 1 өдрөөс хойш төрсөн ЕБС-н сурагч тамирчид оролцоно. Тамирчдын нас тэнцэж байгаар зөвхөн гадаад паспорт,иргэний үнэмлэх,төрсний гэрчилгээ,сурагчиин хувийн хэрэг зэргийг баримтлан шалгаж тэмцээнд оролцох эрх олгоно.

### 5. БАГИЙН МЭДҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭЛ

5.1 УАШТ-нд оролцох багууд нь 10-р сарын 15-ны дотор зохион байгуулах хороонд оролцох тухай батламж, урьдчилсан мэдүүлэг /маягт MVA 0103001/ мэдүүлгийг илгээнэ.

5.2 Техникийн зөвлөгөөн дээр мандат,**гишүүнчлэлийн дэвтэр хураамж**, эцсийн мэдүүлэг /маягт MVA 0103002/, эрүүл мэндийн хуудас /мягт MVA 0103004/, дээр албан ёсны баталгаатай /тамга, тэмдэг/, алдаа засваргүй бөглөж авч ирсэн байна.

### 6. ТЭМЦЭЭНИЙ СИСТЕМ

6.1 Тэмцээнд оролцох багуудыг хэсгүүдэд хуваан урьдчилсан тоглолтыг явуулна.

6..2 Тэмцээн зохион байгуулах талбай дээр албан ёсны ажиллагаа эхлэхээс өмнө багууд бие халаалтын хугацаа харгалзалгүйгээр хийж болно.

6.2.1 Албан ёсны бие халаалт 17 минут үргэлжилнэ.

6.2.2 Албан ёсны мэдүүлэгт ороогүй албаны хүмүүс бие халаалтын үед талбай дээр гарч болох бөгөөд тэмцээн эхэлснээс хойш 1-р шүүгчийн зааврыг дагана.

## 7. БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ БА СУГАЛАА

7.1 Зохион байгуулагчид нь Монголын волейболын холбооны тэмцээн зохион байгуулаж журмыг чандлан мөрдөнө.

## 8. ТОГЛОЛТЫН ДАРААЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

8.1 Сугалааны үр дүнг үндэслэн тоглолтын дарааллыг тогтооно.

8.2 Зохион байгуулагч нь хэвлэл мэдээлэл, ТВ-ийн нэвтрүүлгийн улмаас тоглолтын хуваарийг өөрчлөх эрхтэй. Өөрчлөгдсөн хуваарийг тухайн багуудад 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай.

## 9. ТЭМЦЭЭНИЙГ ШҮҮХ

9.1 Өсвөрийн улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнийг Монголын волейболын холбооны тэмцээн зохион байгуулах журам, Олон улсын волейболын холбооны тоглолтын дүрмийн дагуу явуулна.

9.2 Монголын волейболын холбооны Шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид,баг дагасан шүүгчид тэмцээнийг шүүнэ.

## 10. ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ

10.1 Багийн бүх гишүүд нь сүүлийн 2 сарын хугацаанд баталгаажуулсан эрүүл мэндийн хуудас /маягт MVA 0103004/-ыг үзүүлнэ.

10.2 Тэмцээний туршид ажиллах эмчийг Зохион байгуулах хороо томилно.

10.3 Анхны яаралтай тусламжийг Зохион байгуулах хороо үзүүлнэ.

10.4 Эмнэлгийн үзлэг, уулзалтын өрөөг Зохион байгуулах хороо бэлдсэн байна.

10.5 Баг нь бүх гишүүдийнхээ эрүүл мэндийг даатгалыг хариуцана.

## 11. УРЬДЧИЛСАН ШАЛГАЛТ

11.1 Урьдчилсан шалгалтыг техникийн зөвлөгөөний үеэр зохион байгуулна.

11.2 Урьдчилсан шалгалтыг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

11.3 Багийн менежер, дасгалжуулагч, эмч нар энэ шалгалтын үеэр байлцах шаардлагатай. Шалгалтанд дараах бичиг баримтыг шалгана:

- Эцсийн мэдүүлэг /MVA 0103002 / маягт, тамга, тэмдэг, алдаа засваргүй байх
- Бүх тоглогчдын гадаад паспорт,иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, хувийн хэрэг
- Эрүүл мэндийн худас /MVA 0103004/ маягт, тамга, тэмдэг, алдаа засваргүй байх
- Багийн тоглолтын хувцас (2 өнгө)
- Зар сурталчилгаа хийх батламж

## 12. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

12.1 Техникийн зөвлөгөөн дээр багийн менежер, дасгалжуулагч, эмч, ахлагч нар оролцоно.

12.2 Техникийн зөвлөгөөнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу удирдан явуулна.

12.3 2020 оны 10 дугаар сарын 20 нд 15:00 цагаас Завхан аймгийн БТСГ-ын хурлын танхимд техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

## 13. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ НАС

Тэмцээнд МВХ-ны тэмцээн зохион байгуулах журмыг үндэслэн 2004 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн 16 наснаас доош насны "Ерөнхий боловсролын сургалттай" сургуулийн сурагчид оролцоно.

**Тамирчдын нас тэнцэж байгааг зөвхөн гадаад паспорт, иргэний үнэмлэх,төрсний гэрчилгээ,сурагчиин хувийн хэрэг зэргийг баримтлан шалгаж тэмцээнд оролцох эрх олгоно. / Заавarт заасан ангилалын бус тамирчин оролцсон тохиолдолд эцсийн мэдүүлэгт ороогүй тамирчин тоглосон тохиолдолд багийг тэмцээнээс хасна. Мөн зааварт заасан ангилалын бус тамирчин оролцсон тохиолдолд тухайн багийн дасгалжуулагч, тамирчны эрхийг хасна. /**

(Бага, дунд боловсролын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 10-р зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 1, 14 дүгээр бүлгийн 1 заалт)

**14. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ**

Багуудын танилцуулга, тэмцээнд оролцож буй амжилтын талаар тухайн багууд хэвлэлийн бага хурал хийх болон зохион байгуулагчдын зүгээс тэмцээнийг сурталчилна.

**15. АЛБАН ЁСНЫ ДҮРЭМ, БӨМБӨГ**

15.1 Олон Улсын Волейболын Холбооны тоглолтын дүрмийн дагуу явуулна. Шүүгчдийн шалгалтын дүнгээр ямар нэгэн өөрчлөлт гарч болох ба Техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.

15.2 Тэмцээнийг **MIKASA Volleyball V200W** маркийн бөмбөгөөр явуулна.

**16. ХУВЦАС**

16.1 Тоглолтын хувцас Монголын волейболын холбооны стандартад нийцсэн байна. Баг тус бүр 2 өнгийн хувцастай байх ба зөвхөн нэрийн мэдүүлэгт баталгаажуулсан хувцасыг өмсөнө.

16.2 Хувцасыг буруу өмсөх, стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дүрмийн дагуу торгууль хүлээнэ. (МВХ-ны Тэмцээн зохион байгуулах дүрмийн дагуу) **МВХ-ноос зохион байгуулагдаж буй тэмцээнд оролцож байгаа багууд тоглолтын болон бэлтгэлийн хувцсан /өмсгөл/дээр төрийн далбааг ашиглахыг хориглох бөгөөд төрийн далбаатай өмсгөл хувцастай тоглолтонд оролцуулахгүй./Төрийн далбааг зөвхөн шигшээ багийн тамирчдын өмсгөл хувцсан дээр ашиглана/**

16.3 Тоглолтын хувцасыг урьдчилсан шалгалтын үеэр шалгуулж баталгаажуулна.

16.4 Хажуугийн сандал дээр багийн албаны хүмүүс дараах шаардлагуудын аль нэгийг хангана:

I. Багийн бүх гишүүдийн адил ижил өнгийн хувцас өмсөх
II. Албан ёсны костюм өмсөж, зангиа зүүх
III. Бэлтгэл хангагчаас бусад нь албан ёсны хувцас өмсөх.
IV. Албан ёсны хувцас өмсөөгүй бол багийн гишүүдтэй ойртохыг хориглох ба багийн гишүүдтэй ижил хувцас өмссөн тохиолдолд харилцаа үүсгэж болно.

**17. МАРГААН**

17.1 Тухайн тоглолт дууссанаас хойш 30 минутын дотор багийн менежер эсвэл ахлах дасгалжуулагч нь гомдол гаргах эрхтэй.

**18. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

18.1 Баг тус бүр 12-14 гишүүдээс бүрдэнэ: 12 тоглогч, багийн менежер-1, ахлах дасгалжуулагч-1, туслах дасгалжуулагч-1, эмч-1 байх шаардлагатай.

18.2 Багууд дагалдах шүүгчтэй байж болно.

18.3 Тэмцээн эхлэхээс өмнө багийн илүү албаны төлөөлөгчдийн зардлыг шийдвэрлэсэн бол 2 хүртэлх хүний мандатыг олгож болно.

18.4 Багийн албаны хүмүүс хажуугийн сандал дээр суух ба онцгой тохиолдлоос бусад үед өөрчлөлт хийхийг хориглоно.

18.5 Багийн тоглогчын тоо хамгийн багадаа 9 байж болно.

**19. САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ**

19.1 Баг тус бүр дараах зардлыг хариуцана

a) Эрхийн төлбөр - 300,000 (баг тус бүр)
b) Байр хоолны зардал
c) Мандат-5000 төг (Хүн тус бүр)
d) Гишүүнчлэлийн хураамж- 5000 төг (Хүн тус бүр)

19.2 Зохион байгуулах хороо нь:

a) Эмнэлгийн анхны тусламж
Тэмцээний хуваарийг үндэслэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх баг ажилуулна.

**20. ШАГНАЛ**

20.1 МВХ-ны тэмцээн зохион байгуулах журамд заасан дагуу мөнгөн шагналыг олгоно.

20.2 Медалийг 12 тамирчин 2 дасгалжуулагчид олгоно. Тэмцээнд амжилттай оролцож эхний 3-н байр эзэлсэн тамирчдад медаль, диплом, мөнгөн шагнал олгох ба хувь тамирчны ур чадварыг харгалзан охид, хөвгүүд тус бүрт шилдэг тоглогч шалгаруулна.

Үүнд:

- шилдэг тэгш тоглогч
- Шилдэг холбогч
- шилдэг довтлогч
- шилдэг хамгаалагч
- шилдэг шүүгч
- шилдэг дасгалжуулагч

нийт 8 тамирчин, 2 дасгалжуулагч, 1 шүүгч тусгай шагналаар шагнаж урамшуулна.

**21. МЭДЭЭЛЭЛ**

Тэмцээний өдөр дутмын дүн мэдээг багуудад тараана.

**22. БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ**

Зааварт тусгагдаагүй гарч ирсэн асуудлыг Зохион байгуулах хороо өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.

**МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБОО**

**ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО**